



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠶᠢᠨ
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠢᠮᠢᠶᠢᠨ
ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ


2022

05 сар










www.ubstat.mn

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

www.1212.mn



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	7
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2021 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	182 583	40 317	9 115	37 216	56 398	39 537
Үүнээс:						
Тэмээ	81	32	-	47	2	-
Адуу	15 137	3 940	752	3 245	3 740	3 460
Үхэр	17 327	4 391	1 453	3 695	4 161	3 627
Хонь	90 373	19 482	4 197	18 398	29 686	18 600
Ямаа	59 665	12 462	2 713	11 831	18 809	13 850

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V	2022 I-V
Суурин хүн ам	тоо	29 512	29 663	29 342	29 433	
Төрөлт	тоо	285	256	249	251	205
Нас баралт	тоо	60	63	60	43	80
Шилжиж ирсэн	тоо	254	132	611	207	270
Цэвэр өсөлт	хувь	0.76	0.65	0.64	0.71	0.42'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2021 оны эцсийн байдлаар





БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2022 оны 5 сарын эцэст 304 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 151 (1.9 дахин) хүнээр өссөн байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 11 (3.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, V сарын байдлаар




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 70 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 32 (45.7%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, ШАЛТГААНААР, V сарын байдлаар



Мөн энэ хугацаанд 60 иргэн ажилд орсон бөгөөд хувьцаат компанид 14, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 26, төсөвт байгууллагад 15, улсын болон орон нутгийн үйлдвэрийн газарт 2, бусад байгууллагад 3 иргэн тус тус ажилд орсон байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 42 (13.8%) нь 15-24 насны, 99 (32.6%) нь 25-34 насны залуучууд, 76 (25.0%) нь 35-44 насныхан, 73 (24.0%) нь 45-60 насны, 14.4 буюу (4.6%) нь 60-аас дээш насны иргэд байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, V сарын байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2021 V	2022 V	2021 V	2022 V
Ажилгүйдлийн бүгд	153	304	80	164
Үүнээс:				
Дээд боловсролтой	35	64	21	42
Тусгай дунд боловсролтой	7	15	5	11
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	19	40	3	14
Ерөнхий боловсролтой	86	172	49	91
Бага болон боловсролгүй	6	13	2	5

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 64 (21.1%) нь дээд боловсролтой, 15 (4.9%) нь тусгай дунд боловсролтой, 40 (13.2%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 172 (56.6%) нь ерөнхий боловсролтой, 13 (4.3) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 164 (53.9%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 8.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 855.0 (10.7%) сая төгрөгөөр, зарлага 14.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.2 (27.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 6.0 (67.0%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 626.1 (7.1%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 714.3 (8.1%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 1.5 (16.4%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 124.2 (1.4%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний V сард

Үзүүлэлт	2021		2022		2021.V	2021.I-V
	V	I-V	V	I-V	2022.V	2022.I-V
	сая төгрөг				хувь	
Сангийн орлого, бүгд	1 448.1	8 005.4	1 499.6	8 860.4	103.6	110.7
тэтгэврийн сан	1 021.3	5 571.4	975.7	5 935.2	95.5	106.5
тэтгэмжийн сан	88.5	495.7	103.1	626.1	116.5	126.3
ажилгүйдлийн сан	17.2	98.9	23.7	124.2	137.8	125.6
ҮОМШӨ ¹ -ний сан	98.8	565.7	189.4	714.3	191.7	126.3
ЭМД ² -ын сан	222.3	1 273.7	207.7	1 460.6	93.4	114.7
Сангийн зарлага, бүгд	2 358.6	11 566.7	3 074.8	14 745.9	130.4	127.5
тэтгэврийн сан	2 099.9	1 034.7	2 753.9	13 206.1	131.1	127.6
тэтгэмжийн сан	108.3	464.6	86.9	498.7	80.2	107.3
ҮОМШӨ-ний сан	130.5	657.7	175.3	760.1	134.3	115.6
ЭМД-ын сан	-	-	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	19.9	97.4	58.7	281.0	295.0	288.5

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4738 хүнд 13206.1 сая төгрөгийн тэтгэвэр, 1553 хүнд 498.7 сая төгрөгийн тэтгэмж, 312 хүнд 760.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 104 хүнд 281.0 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний V сард

Үзүүлэлт	2021		2022		<u>2021.V</u>	<u>2021.I-V</u>
	V	I-V	V	I-V	2022.V	2022.I-V
	сая төгрөг				хувь	
Сангийн зарлага	109.6	824.5	1 326.6	7 012.3	12.1*	8.5*
Тэтгэвэр	1.7	315.3	125.3	626.8	73.7*	198.8
Тэтгэмж	33.3	168.7	34.7	170.5	104.2	101.1
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	33.2	136.2	27.8	138.0	83.7	101.3
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	-	-	117.0	-	-
"Алдарт эх" II одонт эхчүүд	-	-	-	157.7	-	-
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	-	-	9.4	39.2	-	-
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	-	-	1 036.8	5 144.4	-	-
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	-	-	56.6	286.9	-	-
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	3.8	18.6	15.2	52.9	4.0*	284.4
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	3.5	7.1	2.0	16.0	57.1	225.4
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	34.1	176.2	15.6	80.2	45.7	45.5
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	-	-	-	19.6	-	-
ОНО-д түшиглэсэн халамж	-	-	-	30.0	-	-
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	2.4	1.2	4.8	-	200.0
Ихэр хүүхдийн тэтгэмж	-	-	2.0	4.0	-	-
Насны хишиг	-	-	-	124.3	-	-

*дахин их


Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 456 хүнд 626.9 сая төгрөгийн тэтгэвэр, 389 хүнд 170.5 сая төгрөгийн тэтгэмж, 257 хүнд 138.0 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 376 жирэмсэн эхэд 39.2 сая төгрөгийн тэтгэмж, алдарт эхийн одонтой 2162 эхэд 274.7 сая төгрөг, 10442 хүүхдэд 5.1 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 1345 хүнд 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 286.9 сая төгрөг 1059 ахмад настанд 52.8 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 1373 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 80.2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 91 иргэдэд 16.0 сая төгрөгийн хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 35 хүн хамруулж 30.0 сая төгрөг, 1507 ахмадад насны хишиг 124.3 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 2 өрхөд 4.0 сая төгрөг, 48 өрх толгойлсон эх, эцэгт 19.6 сая төгрөг тус тус олгосон байна.



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар 220 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 42 (16.0%) буурсан байна. Энэ хугацаанд 133.2 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 71.1 (1.1 дахин) мянган хүнээр, хэвтэн эмчлүүлсэн 3846 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1604 (71.5%) хүнээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 7. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, эхний V сард




ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний V сард

Үзүүлэлт	2021 I-V	2022 I-V	$\frac{2021.I-V}{2022.I-V}$
Амаржсан эхийн тоо	258	220	85.3
Үүнээс бусад аймгийн харьяат	63	53	84.1
Амьд төрсөн хүүхэд	262	220	84.0
Үүнээс бусад аймгийн харьяат	64	50	78.1
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	1	4	400.0

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



ЗУРАГ 9. КОВИД-19, сараар



2022 оны эхний 5 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 70 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 73.7%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 15 (27.3%) тохиолдлоор өссөн бол, цочмог халдварт өвчний 25 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 26.3%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 93 (78.8%) тохиолдлоор буурсан байна.

Тайлант хугацаанд дүүрэгт Ковид-19 өвчний 1604 тохиолдол батлагдсан нь нийт халдварт өвчний 94.4%-ийг эзэлж байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 583.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 523.5 продицимиллээр өссөн байна.

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний V сард

Үзүүлэлт	2021 I-V	2022 I-V	Өсөлт бууралт
Бэлгийн замын халдварт өвчин	55	70	15
Заг хүйтэн	27	30	3
Тэмбүү	14	17	3
Мөөгөнцөр /кандидоз/	1	1	0
Трихомониаз	10	19	9
Кандилом	2	3	1
Хламид	1	-	-1
Цочмог халдварт өвчин	118	1 629	1 511
Цусан суулга	6	3	-3
Гепатит А	2	-	-2
Салхин цэцэг	2	18	16
Ковид-19	95	1 604	1 509
Рож	-	1	1
Сүрьеэ	13	3	-10
Нийт халдварт өвчин	173	1 699	1 526



ГЭМТ ХЭРЭГ


2022 оны эхний 5 сард дүүргийн хэмжээнд 92 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 34 (58.6%) хэргээр нэмэгдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 55.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 12.8 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний V сард

Хэргийн төрөл	2021 I-V	2022 I-V	Хэргийн есөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	58	92	34	58.6	100.0
Хүний амь нас хохирсон	-	4	4	-	4.3
Хүчиндэх	-	2	2	-	2.2
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	37	41	4	10.8	44.6
Гэр бүлийн хүчирхийллийн сэрэг гэмт хэрэг	1	-	-1	-100.0	0.0
Бусдын эд хөрөнгө хулгайлах	2	18	16	9.0*	19.6
Залилан мэхлэх	5	12	7	2.4*	13.0
Дээрэмдэх	1	3	2	3.0*	3.3
Худал мэдээлэл тархаах	1	-	-1	-100.0	0.0
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	3	4	1	33.3	4.3
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үргэгдүүлэх	-	1	1	-	1.1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	1	4	3	4.0*	4.3
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	2	3	1	50.0	3.3
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	1	-	-1	-100.0	0.0
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	2	-	-2	-100.0	0.0
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	2	-	-2	-100.0	0.0
Хэрэг илрүүлэлтийн хувь	42.9%	55.7%			


*-дахин их

ЗУРАГ 10. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 41 (44.6%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг байна. Тайлант хугацаанд бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 18, залилан мэхлэх хэрэг 12, хүний амь нас хохирсон, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн, хөрөнгө завших хэрэг тус бүр 4, хууль сахиулагчийг эсэргүүцэх, дээрмийн хэрэг тус бүр 3, хүчиндэх гэмт хэрэг 2, бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх хэрэг тус бүр 1 бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 11. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, эхний V сард

Хэргийн төрөл	2021 I-V	2022 I-V	Дүнд эзлэх хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	58	92	100.0
Гэр, орон сууцанд	36	44	47.8
Гудамж талбайд	6	12	13.0
Олон нийтийн газарт	-	5	5.4
Аж ахуйн нэгж, байгууллагад	3	9	9.8
Бусад /хөдөө хээр, бэлчээр/	12	19	20.7
Автозам	1	3	3.3

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр нь авч үзэхэд 44 (47.8%) нь гэр, орон сууцанд, 19 (20.7%) бусад газарт, 12 (13.0%) гудамж талбайд, 9 (9.8%) аж ахуйн нэгж, байгууллагад, 5 (5.4%) олон нийтийн газарт, 3 (3.3%) автозамд тус тус үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 12. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний V сард




ЗУРАГ 13. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний V сар



ХҮСНЭГТ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний V сард

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2021 I-V	2022 I-V	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	44	59	15	34.1
Үүнээс: эмэгтэйчүүд	6	8	2	33.3
хүүхэд	-	-	-	-
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	57	94	37	64.9
Үүнээс: нас барсан	-	6	-	-
гэмтсэн	41	45	4	9.8
Эрүүлжигдсэн хүний тоо	205	278	73	35.6
Баривчлагдсан хүний тоо	97	71	-26	-26.8
Учирсан хохирол /сая төгрөг/	160.4	101.3	-59.1	-36.8
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	34.0	30.5	-3.5	-10.3

ЗУРАГ 14. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний V сар



2022 оны эхний 5 сард 59 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 8 (13.6%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд 94 иргэн гэмт хэргийн улмаас хохирсон ба 6 иргэний амь нас хохирч, 45 иргэн гэмтсэн байна. Мөн 278 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 71 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс саатуулагдсан иргэд 73 (35.6%) -аар нэмэгдсэн бол, баривчлагдсан иргэд 26 (26.8%)-аар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 101.3 сая төгрөгийн хохирол учирсны 30.5 (30.1%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.



ҮНЭ ХАНШ


2022 оны 5 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

ХҮСНЭГТ 11. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, V сарын дундаж үнэ


Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	2 200	2 250		2 100
	I зэрэг	кг	1 450	1 400		1 400
	II зэрэг	кг	1 200	1 200		1 150
Будаа	цагаан	кг	3 200	2 850		3 350
	шар	кг	3 100	2 650		3 000
Хонины мах	ястай	кг			10 750	
	цул	кг			12 500	
Үхрийн мах	ястай	кг			13 000	
	цул	кг			15 250	
Адууны мах, ястай		кг			10 750	
Ямааны мах		кг			9 000	
Элсэн чихэр		кг	3 300	3 000		3 300
Сүү /задгай/		л	2 500			
Тараг /задгай/		л	3 000			
Цэцгийн тос, Орос		кг	6 025	5 600		6 050
Байцаа		кг			3 500	
Манжин		кг			2 500	
Төмс	монгол	кг			1 800	
Лууван	монгол	кг			4 000	
Сонгино	хятад	кг			3 500	
	монгол	кг			4 500	
Сармис, булцуу		ш			823	
Огурцы, хятад		кг			10 000	
Помидор, хятад /үрлэн/		кг			12 000	
Ургамлын тос/ siesta/		ш	6 025	5 600		6 050

Өндөг		ш	450	400		450
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	2 000	2 000	2 000
		Дунд 700 гр	ш	1 800	1 900	1 800
		жижиг 500 гр	ш	1 500	1 700	1 500
	Атар талх	ш	1 725	1 750	1 750	

ЗУРАГ 15. "АЛТАН ТАРИА" ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн V сард



ЗУРАГ 16. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн V сард



ХҮСНЭГТ 12. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)	
Дулаан	1м ²	660	1м ³	1632	
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000			
	40м ² - 80м ²	5 000	-	-	
	81м ² -аас дээш	10 000			
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	3 162	1 гкал	76 611

		1м³ (тоолууртай)	1 632		
	Зун	1 хүн (тоолуургүй)	4 428		
Цэвэр ус*			1м³ (тоолууртай)	1 632	
		1 хүн (тоолуургүй)	1.5	1 л (тоолуургүй)	1.50
		1 л (тоолууртай)	1.2	1 л (тоолууртай)	1.20
		Ус түгээх байраар	2.72	1 л (зөөврөөр)	7.5
Бохир ус*		1 хүн (тоолуургүй)	1.5	1 л (тоолуургүй)	1.8
		1 л (тоолууртай)	1.2	1 л (тоолууртай)	1.4
		суурь хураамж	15.0	1 л (зөөврөөр)	1000

ХҮСНЭГТ 13. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	110.5
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	130.3
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	116.4
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	89.2
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
3 тарифт тоолууртай /уул уурхай, боловсруулах аж үйлдвэр/	төг/квт.ц	140.6
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	140.6
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	221.9
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	89.2

* 2019 оны 3 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф

ХҮСНЭГТ 14. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

	2018 V	2019 V	2020 V	2021 V	2022 V
	төгрөг				
Адууны шир	20 000	6 000	8 000	7 000	8 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	15 000	6 000	5 000	3 000	5 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	32 000	10 000	12 000	3 000	5 000
Хонины арьс	2 500	1 500	1 000	1 000	-
Ямааны ноолуур	83 000	100 000	52 500	100 000	85 000

ХҮСНЭГТ 15. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2018 V	2019 V	2020 V	2021 V	2022 V	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 580	1 850	1 450	1 450	2 400	950	65.5
АИ -92	1 730	1 960	1 493	1 470	2 440	970	66.0
Дизель түлш	2 050	2 430	2 180	2 180	3 415	1235	56.7

2022 оны 5 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 970 (66.0%) төгрөгөөр, АИ-80 бензин 950 (65.5%) төгрөгөөр, дизель түлш 1235 (56.7%) төгрөгөөр тус тус өссөн байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2022 оны эхний 5 сард 70.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.1 (3.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, эхний V сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2021 I-V	2022 I-V	$\frac{2021.I-V}{2022.I-V}$	2021 I-V	2022 I-V	$\frac{2021.I-V}{2022.I-V}$
Нүүрс олборлолт	м.тн	1 924.9	1 986.3	103.2	64 484.8	66 541.1	103.2
Дулаан дамжуулалт	м.гкал	87.1	88.3	101.4	3 202.7	3 292.0	102.8
Талх үйлдвэрлэлт	тн	86.4	88.7	102.7	124.3	148.9	119.8
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	25.0	24.2	96.8	242.4	204.4	84.3
Зайлуулсан хог хаягдал	м.м3	24.5	22.0	89.8	258.3	256.3	99.2
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					68 312.5	70 442.7	103.1

ЗУРАГ 17. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар




Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 61.4 (3.2%) мянган тонноор буюу 2.1 (3.2%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 1.2 (1.4%) мянган гкал-аар буюу 89.3 (2.8%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.3 (2.7%) тонноор, үнийн дүнгээр 24.6 (19.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол, нарийн боовны үйлдвэрлэлт 0.8 (3.2%) тонноор буюу 38.0 (15.7%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 22.0 мянган метр куб хог зайлуулсан нь өмнөх оноос 2.5 (10.2%) мянган метр куб-ээр буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 18. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сараар, сая төгрөг



ЗУРАГ 19. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн эхний V сард




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1215.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 301.7 (33.0%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 686.9 (56.5%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна. Орлогын энэхүү өсөлт нь оны эхнээс нэмэгдсэн усны үнийн өсөлттэй холбоотой байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний V сард

Үзүүлэлт	2021 I-V	2022 I-V	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	913.7	1 215.4	301.7
Орон сууц	229.4	347.9	118.5
Ус борлуулалт, бүгд	363.5	405	41.5
Хүн амд	190.9	195.4	4.5
Аж ахуйн нэгжид	172.6	209.6	37
Сувагжуулалт	289.5	405.6	116.1
Бусад	31.3	56.9	25.6

ЗУРАГ 20. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний V сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	236 451.4	234 635.7	99.2
Тавлаг өргөө	41 252.5	45 460.6	110.2
Маргад өргөө	45 889.4	44 635.8	97.3
Сод хөгжил	53 548.5	52 503.0	98.0
Шинэ элч	42 978.4	45 948.2	106.9
Уурхайчин	27 088.6	21 116.7	78.0
Содон суварга	25 694.0	24 971.4	97.2

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2022 оны 6 дугаар сарын 15

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 



©2017


аппликейшнаас


СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn